



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлаар тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НБ:

1.Банзрагч овогтой Энхжаргалыг 2002-2003 оны хичээлийн жилээс АНУ-ын Калифорнийн Олон Улсын Их сургуулийн магистрантурт олон улсын бизнесийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2.Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 225 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД


А.ЦАНЖИД